



БАТЛАВ

"ЗАМ, ТЭВРИЙН ХӨГЖЛИЙН ТӨВ"

ТӨГ-ЫН ЗАХИРАЛ

Х.ПҮРЭВЖАРГАЛ

**"ГУДАМЖ ЗАМЫН ГАДАРГУУН УС ЗАЙЛУУЛАХ БАЙГУУЛАМЖИЙН БҮТЭЦИЙН ЖИШИГ  
ЦОМОГ ЗУРАГ" ОРЧУУЛАН БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН ДААЛГАВАР**

2022 оны <sup>10</sup> сарын <sup>05</sup>-ны өдөр

№1

Улаанбаатар хот

**1. Төсөл боловсруулах  
үндэслэл:**

- "Авто замын норм нормативын сангийн хөрөнгөөр 2022-2023 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төлөвлөгөө"

**2. Төслөөр шийдвэрлэх  
асуудал:**

- Хот, сууринь газрын гудамж замын гадаргуун усыг зайлуулах байгууламжийн зургуудыг нэгтгэсэн цомог болох бөгөөд автомашин болон явган зорчигчид аюулгүй, тав тухтай саадгүй зорчих нөхцлийг бүрдүүлнэ;
- Авто замын хучилтын ус зайлуулах байгууламжийг төлөвлөх ерөнхий зарчимд тулгуурлан ус зайлуулах байгууламжийг газар зүйн нөхцөлд тохируулан иж бүрэн оновчтой төлөвлөх;
- Гадны орны шалгарсан стандарт болон жишиг цомгийг орчуулан үндэсний болгон нутагшуулах;
- Авто замын гадаргуун ус зайлуулах байгууламжийн тоо хэмжээ, гүйцэтгэл мэдээллийг ил тод болгоно;
- Газар зүйн ижил төстэй зам-цаг уурын ойролцоо бүсэд орших улс орнууд /ОХУ, БНХАУ, Казахстан, Канад, Япон-ын стандарт, норм дүрэм, техникийн баримт бичгүүдээс судалж, оновчтойг сонгон өөрийн орны онцлолт тохируулан орчуулан боловсруулах;

**3. Төслийн иж бүрдэл:**

- Автомашинь даац авах чадвартай байх;
- Жишиг цомогоор бүтээгдэхүүний бүтээц, нэр төрөл ба хэмжээсийг тодорхойлсон байх;
- Нэр төрөл, хэмжээсийн дагуу тоо хэмжээг тодорхойлсон байх;

- Олон улсын шалгарсан олон жилийн судалгаатай стандарт, жишиг цомгийг судлах;
- Манай улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа стандарт, нормтой уялдуулах;

**4. Төслийн хүрээнд  
боловсруулах эцсийн үр**

- Борооны усыг богино хугацаагаар зайлуулж зам дээр ус тогтохоос сэргийлж, автомашин болон явган зорчигчдын аюулгүй байдлыг хангах, иргэдийн ая

дүн, түүний шинэлэг ба давуу тал ач холбогдол:

Тухтай зорчих болон бизнесийн үйл ажиллагаанд саад учруулахгүй чанартай, барилгын ажлыг хэрэгжүүлэхэд хялбар болно;

- Шинэ гарсан технологи, “Зам замын байгууламжийн норматив техникийн баримт бичгийн ерөнхий тогтолцоо” MNS 6598-2016 стандартад болон орчин үеийн шаардлага, эрх зүйн баримт бичиг, бусад холбогдох стандартад, норм дүрэм, аюулгүйн техник, үйлдвэрлэлийн эрүүл ахуйн норматив баримт бичгүүдтэй уялдуулан шинэчлэн боловсруулагдсан байна;

5. Төслийг хэрэгжүүлэх байгууллага:

- “Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨҮГ, Тухайн чиглэлээр мэргэшсэн, туршлага бүхий Зөвлөх баг болон хуулийн этгээд (Сонгон шалгаруулалтаар) байна;

6. Төслийг хэрэгжүүлэх хугацаа:

- 6 сар (Гэрээ байгуулагдсан өдрөөс хойш)

7. Төслийг хэрэгжүүлэх хөрөнгийн эх үүсвэр:

- “Авто замын норм нормативын сан”

8. Төсөлд хөрөнгийн хэмжээ:

- 20.0 сая төгрөг

9. Төслийн онцгой нөхцөл:

- Бетон суваг, үерийн ус зайлуулах хоолой, Техникийн шаардлага MNS AASHTO M86 M:2005, Ус зайлуулах болон ариутгах татуургын MNS ASTM C 76 M:2004, Угсармал бетон, төмөрбетон бүтээц, эдлэхүүн, Техникийн ерөнхий шаардлага MNS 2228:2002, Портланд цементад Техникийн шаардлагуудыг ишлэл болгох;
- Гудамж замын гадаргын ус зайлуулах байгууламжуудын шинж чанарыг тодорхойлсон байх;
- Ус зайлуулах байгууламжийг нутаг дэвсгэр, гудамж замын гадаргуун талбай, налууг үндэслэн тухайн газрын нөхцөлд тохирох байгууламжийг сонгох боломжтой байх;
- Ус урсах нөхцлийг хангасан байх;
- Судалгааны ажлын хүрээнд цуглуулсан мэдээлэл, судалгааны үр дүн, тайлан, боловсруулагдсан аливаа программ хангамж, түүний эх код нь “Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай” хуулийн 17.2.18 дугаар зүйлийн дагуу Зам, тээврийн хөгжлийн төвийн өмч болно;
- Төслийн хүрээнд боловсруулсан, ашигласан бүх цахим болон хэвлэмэл материал, программ хангамж зэргийг эх хувиар эцсийн тайлангийн хамт Захиалагчид хүлээлгэн өгөх;

- Зөвлөх нь төсөл боловсруулахад шаардлагад гадаад орны стандарт, нормыг хамгийн сүүлийн хувилбараар нь худалдан авах үнийг зардлын төсөвтөө тусгах ба төсөл дууссаны дараа эдгээр баримт бичгийг эх хувиар нь Захиалагчид хүлээлгэн өгөх;
- Зөвлөх үйлчилгээний үе шатны тайланг “Эрдэм шинжилгээний ажлын тайлан. Бүтэц шаардлага” MNS 2492:2004, Монгол улсын стандартчиллын тогтолцооны суурь стандарт MNS 1.1-2006, MNS 1.2-2006 стандартын дагуу боловсруулах;
- Төслийн боловсруулалтын явцад салбарын байгууллага, ИТА-уудыг хамруулсан 2-оос доошгүй удаа нээлттэй хэлэлцүүлгийг зохион байгуулж, төсөлд санал авах;
- Салбарын мэргэжлийн холбоод, төрийн болон төрийн бус байгууллага, зөвлөх инженерүүдээс санал авч нэгтгэх, саналыг төсөлд хэрхэн тусгасан талаар тайлбар, танилцуулга хийх;
- Төсөлд Төвийн Захирлын тушаалаар байгуулагдсан редакци, шүүмжийн ажлын хэсгээр шүүмж хийлгэх;

**Хянасан:**

“Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨҮГ-ын Бодлогын хэрэгжилт, зураг төслийн магадлал, стандарт, норм нормативын хэлтсийн дарга



Д.БАЗАРСАД


Нийслэлийн замын хөгжлийн газрын Бодлого төлөвлөлтийн хэлтсийн ахлах мэргэжилтэн



Б.АНХБАЯР

**Боловсруулсан:**

Нийслэлийн замын хөгжлийн газрын замын Стандарт, норм норматив хариуцсан мэргэжилтэн



Г.УНДРАМ